



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“2016, 2017 оны аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын
төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан**



**Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль,
тогтоомжийн дагуу бүрэн зохион байгуулаагүй ба эмийн
зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.**

***Баянхонгор хот
2018 оны 09 дүгээр сар***

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар

Газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах аудитор Б.Должмаа
Аудитор Б.Азбаяр
П.Мөнх-Эрдэнэ
Б.Нарангэрэл

2018 оны 09 дүгээр сар

Уг тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.

Хаяг: Баянхонгор сум, Номгон
1-р баг, Төр захиргааны ордон
3-р давхар

Товчилсон Үгийн тайлбар.....	2
Гүйцэтгэлийн аудитын тайлан.....	3
Гүйцэтгэлийн аудитын дүн.....	5
Бүлэг 1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг Сангийн яамнаас бууруулж баталснаас эмийн өглөг үүсч, оны эцэст зардлыг нэмж тодотгосон байна.....	5
1.1 Эмийн зардлыг өмнөх оны гүйцэтгэл, тасаг нэгжүүдийн захиалгад үндэслэн төлөвлөжээ.....	5
1.2 Төсвийн төсөлд тусгасан эмийн зардлыг бууруулж баталсан байна.....	6
Бүлэг 2. Эмийн худалдан авалтыг зохих хууль журмын дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн программийн удаа дараагийн гэмтэл нь эмийн бүртгэлийн хэвийн ажиллагааг алдагдуулж байна.....	7
2.1 Гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгжүүдээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, зарим байгууллагаас гэрээний дүнг хэтрүүлэн худалдан авалт хийжээ.....	7
2.2. Эмийн дотоод шилжүүлгийн орлогыг тухай бүр бүртгэлд тусгадаггүйгээс тасаг нэгжээс ирүүлсэн захиалгын хуудсын дагуу эмийн зарцуулалтыг хөтлөөгүй байна.....	13
Бүлэг 3. Санхүүгийн тайланд өглөг, авлагыг үнэн зөв тусгаагүй, эмийн эмчилгээг зохицуулах хорооноос тавих хяналт зарим талаар хангалтгүй байна.....	20
3.1 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлээгүй зөрчилд зөвлөмж өгсний үр дүнд 2017 онд бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж, хугацаанд нь актаар баталгаажуулсан байна.....	20
3.2. Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай хийсэн гэрээний хэрэгжилтэд эмийн эмчилгээг зохицуулах хороо хяналт тавьж ажиллаагүй байна.....	24
Холбогдох байгууллагын санал.....	26
Аудитын дүгнэлт.....	27
Аудитын зөвлөмж.....	28-29
Хавсралт судалгаа.....	30-32
Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага.....	33-48

Товчилсон Үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
СС	Сангийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хавсралт судалгааны жагсаалт

Хавсралт №1	Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дүнг худалдан авалттай харьцуулсан судалгаа
Хавсралт №2	Эмийн солилцоо хийсэн судалгаа
Хавсралт №3	Эмийн солилцоогоор авсан эмийг гэрээний дүнтэй харьцуулсан судалгаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 тоот тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ:

Аудитын явцад дараах асуудалд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд

1. Эмийн зардлыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулсан уу?
2. Эмийн худалдан авалтыг хууль, журмын дагуу хийж, бүртгэлд бүрэн тусгасан уу?
3. Санхүүгийн тайланд авлага, өглөгийг үнэн зөв тусгаж, хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Аудитад аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016, 2017 оны эмийн зардлыг хамруулж, аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгээс авсан санхүүгийн тайлан, анхан шатны баримт, тушаал шийдвэр, журам, заавар, мэдээ, тайлан, судалгаа бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, санхүүгийн тайлан, статистик мэдээ, тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох баримт цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль /2003.01.03, 2013.11.07/
- Төсвийн тухай хууль /2011.12.23/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015.06.19/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль /2005.12.01/
- Эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль /2011.05.05/
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай Монгол улсын хууль /2010.05.27/
- Мансуурах эм, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай Монгол улсын

хууль /2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр/

- Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай /УИХ-ын тогтоол 2014 оны 10 дугаар сарын 19-ны өдөр №57 /
- Үндэсний хөтөлбөр батлах тухай /МУ-ын ЗГ-ын тогтоол 2017 оны 04 сарын 12-ны өдөр №112 /
- Эмийн Эмчилгээг Зохицуулах Хороо ажиллах журам батлах тухай /ЭМС-ын 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 336-р тушаал/
- Мансуурах, сэтгэц нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай /ЭМС-ын 68-р тушаал/
- Журамд өөрчлөлт оруулах тухай /ЭМС-ын тушаал 2016 оны 05 сарын 18-ны өдөр/
- Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай /ЭМС-ын 2009 оны 11 сарын 17-ны өдөр 388 дугаар тушаал/
- Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлх журам /ЭМС-ын 2010 оны 378 дугаар тушаал/
- Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журмын тухай /ЭМС, СС-ын хамтарсан 2012 оны 04 сарын 20-ны өдөр №129/100 тушаал/
- Жагсаалт шинэчлэн батлах тухай /Зайлшгүй шаардлагатай эмийн 8 дахь жагсаалт/ /ЭМС-ын тушаал 2017 оны 09 сарын 07-ны өдөр А/350 /
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
- Холбогдох бусад эрхийн актууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрд хяналт тавьж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл, Б.Азбаяр нар 2018 оны 08 дугаар сарын 13-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, ерөнхий нягтлан бодогч, эмийн нягтлан бодогч болон эмийн сангийн ажилтнуудтай “Төгсгөлийн уулзалт”-ыг зохион байгуулж, гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчил болон тайлангийн төсөлд тусгагдсан асуудлуудын талаар харилцан санал солилцов.

Аймгийн ИТХ-ын захиалгын дагуу хийж гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн ИТХ, Нэгдсэн эмнэлэгт албан тоотоор 2018 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1

Эмийн зардлыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулсан уу?

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг Сангийн яамнаас бууруулж баталснаас эмийн өглөг үүсч, оны эцэст зардлыг нэмж тодотгосон байна.

1.1 Эмийн зардлыг өмнөх оны гүйцэтгэл, тасаг нэгжүүдийн захиалгад үндэслэн төлөвлөжээ.

1.1.1. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг нь тухайн жилийн төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу 2016 оны төсвийн төслийг эдийн засагч Л.Наранцэцэг, 2017 оны төсвийн төлөвлөгөөний төслийг ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал нар бэлтгэн аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлжээ.

Өмнөх оны болон тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл, тасаг нэгжүүдээс ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга зэргийг үндэслэн дараа жилийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах зардлын төсвийн төслийг боловсруулсан байна.

Эмийн зардлын гүйцэтгэл, төсвийн төлөвлөгөөний төслийг он тус бүрээр харуулбал:

/мянган төгрөг/

д/д	Эмийн нэр төрөл	Тасаг, нэгж	2016 он			2017 он			2016 он	2017 он
			2014 оны гүйцэтгэл	2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөөний төсөл	2015 оны гүйцэтгэл	2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	2017 оны төлөвлөгөөний төсөл	Өөрчлөлт	Өөрчлөлт
1	Эм тариа	Амбулатори	27,850.4	36,093.5	36,146.4	24,549.8	33,682.3	35,928.6	52.90	2,246.30
		Хэвтэн эмчлүүлэх	285,075.7	374,060.0	678,290.3	364,793.6	599,967.1	648,079.2	304,230.30	48,112.10
2	Эмнэлгийн хэрэгсэл	Амбулатори	16,356.3	21,186.8	21,222.5	15,874.3	21,779.5	23,232.1	35.70	1,452.60
		Хэвтэн эмчлүүлэх	167,425.5	219,697.0	223,351.4	197,408.2	409,393.2	426,735.3	3,654.40	229,327.10
3	Лабораторийн урвалж, оношлуур	Амбулатори	90,209.1	125,679.1	130,108.2	90,805.1	124,888.7	132,942.5	4,429.10	8,053.80
		Хэвтэн эмчлүүлэх	68,052.5	91,009.0	101,457.7	70,492.5	96,715.6	103,165.8	10,448.70	6,450.20
4	Цус, цусан бүтээгдэхүүн	Хэвтэн эмчлүүлэх	10,536.0	8,602.3	9,462.6	9,849.7	13,329.3	14,414.9	860.30	1,085.60
5	Төлбөрийг нь Төр хариуцах эм	Амбулатори	7,947.8	15,314.5	16,820.5	7,691.4	12,108.4	15,374.8	1,506.00	3,266.40
Нийт дүн			673,453.3	891,642.2	1,216,859.6	781,464.6	1,311,864.1	1,399,873.2		

Судалгаанаас харахад 2016 онд хэвтэн эмчлүүлэгчдийн эм тарианы зардал өмнөх оны гүйцэтгэлээс 304,2 сая төгрөгөөр нэмэгдсэний 250,0 сая төгрөг нь хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн диализын 4 ширхэг аппаратыг ашиглалтад оруулахтай холбоотой байна.

Харин 2017 оны эмнэлгийн хэрэгслийн зардал 229,3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Нэгдсэн эмнэлэг дурангийн хагалгаа хийж эхэлсэнтэй холбоотой хагалгаанд ашиглагдах нэг удаагийн хэрэгслүүдийг худалдан авах зардлыг тусгасан байна.

Дараа оны төсвийн төсөлд эмчилгээ үйлчилгээнд шинээр нэвтэрч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг тасаг нэгжүүдэд танилцуулан саналыг авдаг бөгөөд тухайн шинэ эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн саналын судалгаа, танилцуулга, хэрэглэх заавар зэргийг нийлүүлэгч байгууллагуудаас албан бичгээр авч төсөлд тусгадаг байна.

1.2 Төсвийн төсөлд тусгасан эмийн зардлыг бууруулж баталсан байна.

1.2.1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016 оны эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 1093,8 сая төгрөг хуваарилагдаж, төсвийн тодотголоор эмийн зардлыг 67,1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1160,9 сая төгрөгөөр баталжээ. 2017 онд тус зардалд 1150,0 сая төгрөг хуваарилагдсан ба төсвийн тодотголоор зардлыг 33,4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардалд 1183,4 сая төгрөг баталжээ.



Дунджаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт төсвийн 18,3 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал эзэлж байна.

Төсвийн төсөлд тусгагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг батлагдсан төсөвтэй харьцуулбал:

/мянган төгрөг/

д/д	Эдийн засгийн ангилал	2016 оны төсвийн төлөвлөгөөний төсөл	2016 оны батлагдсан төсөв	Зөрүү	2017 оны төсвийн төлөвлөгөөний төсөл	2017 оны батлагдсан төсөв	Зөрүү
1	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардал	1,216,859.60	1,093,835.90	123,023.70	1,399,873.20	1,150,024.10	249,849.10

Дээрх судалгаанаас авч үзэхэд Сангийн яамнаас аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн төсөлд тусгасан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг 2016 онд 123,0 сая, 2017 онд 249,8 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Сангийн яам төсвийн төслийг үндэслэлгүйгээр бууруулснаас тайлант хугацаанд эмийн өглөг үүссэний улмаас эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах авах зардлыг 2016 онд 67,1 сая, 2017 онд 33,4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

БҮЛЭГ 2

Эмийн худалдан авалтыг хууль, журмын дагуу хийж, бүртгэлд бүрэн тусгасан уу?

Эмийн худалдан авалтыг зохих хууль журмын дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн программийн удаа дараагийн гэмтэл нь эмийн бүртгэлийн хэвийн ажиллагааг алдагдуулж байна.

2.1 Гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгжүүдээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, зарим байгууллагаас гэрээний дүнг хэтрүүлэн худалдан авалт хийжээ.

2.1.1. Аймгийн Нэгдсэн эмнэлэг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн захиалгыг батлагдсан төсвөөс 2016 онд 118,3 сая, 2017 онд 30,8 сая төгрөгөөр хасч Орон нутгийн өмчийн газарт захиалга өгчээ. Энэ нь тендерийн үр дүн гарах хүртэлх хугацаанд аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, эмийг худалдан авсан гэх боловч эм ханган нийлүүлэх байгууллагуудтай хийсэн 2016 оны 135,9 сая, 2017 оны 95,1 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээний хүчинтэй хугацаа тайлант оны 12 сард дуусахаар заасан байна. Энэ талаар эмийн нягтлан бодогчоос тодруулахад “Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн гэрээг байгуулахдаа санхүүгийн тайлант оноор тасалбар болгож байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлж буй гүйцэтгэгчид тендерийн хугацааг дуусахаар тендерийн үнээр нийлүүлэх боломжгүй байдаг бөгөөд дараа оны тендерийн үр дүнг гарах хүртэлх хугацаанд хамтран ажиллах гэрээг байгуулж, эмийг тасралтгүй хангах нөхцөл бололцоо үүсдэг” гэсэн тайлбар өгөв.

Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай байгуулсан гэрээний дүнг тайлант жилийн худалдан авалттай харьцуулж үзэхэд гэрээний дүнг мөрдөж ажиллаагүй байна. /Хавсралт 1/

2016 онд 24 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж 1098,5 сая, 2017 онд 25 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж 1066,2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан ба хамтран ажиллах гэрээ байгуулаагүй атлаа 2016 онд 11 аж ахуйн

нэгжээс 24,0 сая, 2017 онд 2 аж ахуй нэгжээс 1,6 сая төгрөгийн худалдан авалт хийж, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Бараа материалын орлогын журналыг эм тус бүрээр, нэгж үнээр сортлон, тендерийн гэрээний тодорхойлолтод заасан нэгж үнэтэй тулгаж үзэхэд 2016, 2017 онд нийт 900.9 мянган төгрөгийн эмийг гэрээний үнээс илүү үнээр нийлүүлсэн байна.

/мянган төгрөг/

д/д	Бэлтгэн нийлүүлэгч	Эмийн нэр төрөл	Гэрээний үнээс илүү авсан мөнгөн дүн	
			2016	2017
1	Бүрэн хайрхан сервис ХХК	6	352.1	156.1
2	Монгол фарм ХХК	4	20.0	159.0
3	Монос фарм трейд ХХК	9	69.6	108.1
4	Мөнхийн тун ХХК	1		36.0
Нийт дүн		20	441.7	459.2

Иймд тендерийн гэрээний үнээс илүү үнээр нийлүүлсэн эмийн үнийн зөрүүг дээрх бэлтгэн нийлүүлэгч аж, ахуй нэгжүүдээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Эм хангах нийлүүлэх байгууллагуудтай хийсэн гэрээний дүнгээс 2016 онд 74.0 сая, 2017 онд 123.7 сая төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн ба гэрээнд тусгагдаагүй эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан, тендерийн үнээс өндөр үнээр худалдан авсан зэргээр холбогдох хуулиудыг зөрчсөн байна. Тухайлбал:

Бэлтгэн нийлүүлэгч нартай байгуулсан гэрээний үнийн дүнг Нэгдсэн эмнэлгийн эмийн орлогын дүнтэй тулгаж үзэхэд 2016 онд "Айвико" ХХК-тай 104,0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 212,6 сая төгрөгийн худалдан авалт хийж, гэрээний дүнг 108.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь хамгийн их дүнтэй байна. Харин "Нарт Эрдэнэс" ХХК-тай 195,5 сая төгрөгийн гэрээ байгуулсан атлаа тайлант онд 49.1 сая төгрөгийн худалдан авалт хийж, 146.4 сая төгрөг гэрээний худалдан авалт хийгдээгүй байна. Үүнийг тодруулахад "Гемодиализын эмчилгээнд хэрэглэгдэх эм, шингэнүүд" буюу 27-р багцад шалгарсан "Нарт Эрдэнэс" ХХК-ийн шингэн нь гемодиализийн аппаратыг гэмтээж байсан учраас дахин худалдан авалт хийлгүйгээр "Айвико" ХХК-аас худалдан авалтыг хийсэн гэсэн тайлбарыг өгсөн. Мөн "Мөнхийн тун" ХХК нь 44.2 сая төгрөгөөр гэрээний үнэ хэтэрсний 30.0 сая төгрөгөөр 19800 үнэ бүхий 1515 ширхэг Эх барих цомог гэрээгүй хүлээн авсан нь нөлөөлжээ.

¹ "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно"

2017 онд “Монгол фарм” ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүн 123,0 сая төгрөгөөр хэтэрснийг тодруулахад “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд 27,7 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулсан ба тендерийн 2, 3 дахь шалгаруулалт хүртэл тасалдаж байгаа эм тариа мөн аймгийн Засаг даргын захирамжаар зорилтот бүлэгт үзлэг шинжилгээ хийх гэнэтийн хэрэгцээ шаардлага гарсны дагуу сорил тестүүдийг гэрээгүй авч, нэмэлтээр үнийн дүнгүй гэрээг “Монгол фарм” ХХК-тай 3 удаа байгуулсан байна.

“Монос фарм” ХХК-тай 2017 онд 88,6 сая төгрөгийн гэрээ байгуулсан байхад гүйцэтгэлээр 117,2 сая төгрөгийн худалдан авалт хийж, гэрээний дүнг 28,6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байгаа нь тухайн үед эмийн сангийн нөөцөд байхгүй эм тариа авсан гэсэн тайлбарыг өгсөн болно. Харин “Эм хангамж” ХХК-тай 171,8 сая төгрөгийн гэрээ байгуулсан атлаа 100,1 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, гэрээний дүнгээс 71,6 сая төгрөгөөр бага худалдан авалт хийсэн нь эмнэлгийн эмийн сангийн нөөцөд үлдэгдэл өндөртэй байгаа эмүүдээ багасгах, авахгүй байх тохиолдол байдаг гэсэн тайлбаруудыг өгсөн.

“Бүрэнхайрхан сервис” ХХК-аас 2016 оны эхэнд тендер зарлаагүй байхад Перкисийг нэг бүрийг нь 6500 төгрөгөөр, жавелоныг 199 төгрөгөөр худалдан авч байсан бөгөөд тендер шалгаруулалтын дараа байгуулсан гэрээнд перкисийг 2800 төгрөгөөр, жавелоныг 110 төгрөгөөр худалдан авахаар заасан бөгөөд гэрээнд заасан тоо хэмжээ дуусмагц нэг бүрийг перкисийг 5900 төгрөгөөр, жавелоныг 193 төгрөгөөр худалдан авсан байна. Дээрх эмнэлгийн хэрэгслийг гэрээний үнээр бэлтгэсэн бол төсвийг 2237,8 мянган төгрөгөөр хэмнэх боломж байжээ.

Гэрээний дүнг баримталж ажиллаагүй шалтгааныг тухайн жилийн өвчлөлтэй холбон тайлбарлаж байгаа бөгөөд цаашид тендерийн баримт бичгийг боловсруулахдаа техникийн тодорхойлолтод худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээг тухайн жилийн өвчлөлтэй холбоотойгоор их эсвэл бага хэмжээгээр, гэрээнд заасан үнээр худалдан авах нөхцлийг зааж, гэрээнд энэ талаар тусгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм ханган нийлүүлэх байгууллагуудтай байгуулсан гэрээнд нийлүүлэхээр заасан эм, эмнэлгийн хэрэгслийг тухайн онд



худалдан авсан эмийн нэр төрөлтэй тулган шалгахад гэрээнд тусгагдаагүй эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2016 онд 372,7 сая, 2017 онд 315,7 сая төгрөгийн тендерийн бус худалдан авалт хийжээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг тендерт шалгарсан болон шалгараагүй зарим аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээг оны эхэнд байгуулсан ба гэрээнд эмийн нэр төрлийг заагаагүй, гэрээ нь хавсралтгүй, үнийн дүн заагаагүйгээс эмийг ямар үнээр авах нь тодорхойгүй байна. Энэ талаар эмийн нягтлан бодогчоос тайлбар авахад “Бид шаардлагатай эмийн саналыг утсаар тодруулан судалгаа хийж гэрээний үнийг тогтдог, тухайн оны тендерийн үр дүн гарах хүртэл тухай байгууллагаас ямар ч эм авч магадгүй учраас гэрээнд хавсралт хийдэггүй” гэсэн тайлбарыг өгч байгаа боловч эм, эмнэлгийн хэрэгсэлд үнийн судалгаа хийсэн нь нотлогдохгүй байна. Энэ нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар баталсан “Эм, эмнэлгийн хэрэгслийг захиалах, хуваарилах, хүлээн авах, хадгалах, түгээхэд баримтлах дотоод журам”-ын 2.2² –д заасныг зөрчиж байна.

2.1.3. Аймгийн нэгдсэн эмнэлэг 2016 онд эм ханган нийлүүлэх 5 байгууллагаас 9 удаагийн 103 нэр төрлийн 220061 ширхэг буюу 18,8 сая төгрөгийн, 2017 онд эм ханган нийлүүлэх 4 байгууллагаас 11 удаагийн 70 нэр төрлийн 60800 ширхэг буюу 21,4 сая төгрөгийн эмийн солилцоог хийсэн байна. /Хавсралт 2/

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2016 онд “Мөнхийн тун” ХХК-аас эмийн солилцоогоор авсан 14713,9 мянган төгрөгийн эмийг 14803,9 мянган төгрөгөөр буюу 90,0 мянган төгрөгөөр илүү орлого авсан зөрчил илэрлээ. Тухайн жилийн өвчлөл их

² “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна..”

байснаас захиалгаасаа илүү хэрэгцээ үүсдэг, эмч нар солигдсоноос эмчилгээний арга барил өөрчлөгдөж, улмаар эмийн үлдэгдэл их байх үед болон хугацаа нь дуусах дөхсөн эмийг тасалдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгслээр солилцдог гэж эмийн нягтлан бодогч, нөөцийн тасгийн эм зүйч нар тайлбар хийж байгаа боловч байгууллагын төсвийн менежер, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, ерөнхий нягтлан бодогч, эмийн эмчилгээний хороонд танилцуулсан тухай нотлох баримт ирүүлээгүй болно.

2017 онд бэлтгэн нийлүүлэгч компанитай солилцоогоор авсан 70 нэр төрлийн эмийг тендерийн гэрээний үнэтэй харьцуулахад 51% хувь буюу 36 нэр төрлийн эмийг 9-191%-ийн нэмэгдэлтэй үнээр, 13 хувь буюу 9 нэр төрлийн эмийг 2-50%-ийн бага үнээр, 36% буюу 25 нэр төрлийн эмийг гэрээний үнээр солилцсон үзүүлэлттэй байна.



Аудитаар тухайн жилд солилцсон эмийн үнийг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнэтэй харьцуулахад 50%-аас дээш үнийн нэмэгдэлтэй үнээр 1773,7 мянган төгрөгийн 13 нэр төрлийн эм, эмнэлгийн

хэрэгслийг солилцож, батлагдсан төсвийг 1773,7 мянган төгрөгөөр хэмнэх боломжийг алдсан байна. /Хавсралт 3/

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай эмийн солилцоог хийхдээ аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч үнийн судалгааг гаргаагүй, ямар компанитай, хэдэн төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг ямар үнээр солилцсон тухай тайлан, мэдээллээр удирдлагуудыг хангаагүй, эмийн солилцоог эмийн нягтлан бодогч, нөөцийн тасгийн эм зүйч нарын сонголтоор хийж ирсэн, Нэгдсэн эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хорооноос хяналт тавьдаггүйгээс төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт сул байгааг харуулж байна.


2017 оны солилцооноос 42 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг түүвэрлэн авч үзэхэд тайлант хугацаанд худалдан авсан 28 нэр төрлийн эмийг солилцсон байна. Энэ талаар эмийн нягтлан бодогчоос тодруулахад “Урд жилүүдэд хэрэгцээ

их байсны улмаас 2017 онд их хэмжээгээр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл нь өвчлөлөөс шалтгаалж бага хэмжээгээр зарцуулагдаж үлдэгдэл ихтэй болсон тул солилцсон” гэсэн тайлбарыг өгсөн.

Иймд аудитаар эмийн солилцоо хийх журам дотооддоо боловсруулан мөрдөж, эмийн солилцоонд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг хүргүүлэв.

2.1.4. Нэгдсэн эмнэлгийн эмийн санд стандартаар байвал зохих орон тооноос дутуу орон тоогоор ажилладаг бөгөөд нөөцийн тасаг, эм олгох хэсэг, найрлага шингэн, гемодиализ, хүчилтөрөгч гэсэн хэсгүүдээр дамжуулан эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг олгодог байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг төсвийн хөрөнгөөр 2016 онд 1156,3 сая, 2017 онд 1174,7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсныг санхүүгийн тайланд бүрэн тусгажээ.



Нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ны А/41 тоот тушаалаар томилогдсон 6 хүний бүрэлдэхүүнтэй эм эмнэлгийн хэрэгсэл хүлээн авах, зөөх, хураах комисс тайлант хугацаанд худалдан авсан болон солилцоогоор авсан эм, эмнэлгийн хэрэгслийг зохих журмын дагуу акт үйлдэж, хүлээж аваагүй байна.

2017 оны 10 дугаар сараас эмийг хүлээн авахдаа бараа материал хүлээн авах журналыг хөтөлсөн ба нийт 249,4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авснаас 50,8% буюу 126,8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг акт үйлдээгүй хүлээн авсан байна.

/сая төгрөг/

2017 он	Журналаар хүлээн авсан дүн	Акт үйлдээгүй дүн	Нийт худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн дүн
10 сар	66.4	40.1	106.5
11 сар	47.6	7.5	55.1
12 сар	8.6	79.2	87.8
Нийт	122.6	126.8	249.4

2.2. Эмийн дотоод шилжүүлгийн орлогыг тухай бүр бүртгэлд тусгадаггүйгээс тасаг нэгжээс ирүүлсэн захиалгын хуудсын дагуу эмийн зарцуулалтыг хөтлөөгүй байна.

2.2.1 Аймгийн Нэгдсэн эмнэлэг “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программаар эмийн орлого, зарлагын бүртгэлийг хөтөлж байна. Санхүүгийн программд эмийн орлогыг эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг оруулж, нөөцийн тасгаас олгох хэсэгт шилжүүлсэн зарлагын гүйлгээг нөөцийн тасгийн эм зүйч программд шивж, тасгуудад олгосон эмийн зарлагын гүйлгээг олгох хэсгийн эм зүйч хийдэг байна.

Эмийн нягтлан бодогч бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан эмийг санхүүгийн программд орлогоор бүртгэхдээ хэмжих нэгжийг буруу оруулдаг, савлагаа нь өөр нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг баазад хадгалагдсан нэрээр бүртгэдэг зэрэг зөрчлүүд байна. Эмчилгээ эрхэлсэн орлогч даргаар батлуулсан тасгийн захиалгын хуудсаар Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн олгох хэсгээс эм, эмнэлгийн хэрэгслийг олгож, сарын эцэст эм зүйч захиалгын хуудсаар эмийн түүврийг бэлтгэж, түүнийг эмийн нягтлан бодогч хянаж, сарын эцэст санхүүгийн программд зарлагыг бүртгэдэг байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар баталсан “Эм, эмнэлгийн хэрэгслийг захиалах, хуваарилах, хүлээн авах, хадгалах, түгээхэд баримтлах дотоод журам”-ын 3.2³-д заасныг зөрчиж зарим тасгийн захиалгын хуудас ахлах сувилагчийн гарын үсэггүй,

³ “Тасаг, нэгжээс орж ирсэн баталгаажсан захиалгын дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурыг олгож, хүлээн авсан ахлах сувилагч гарын үсэг зурж, хүлээлгэн өгсөн эм зүйч, эм найруулагч гарын үсэг зурснаар баримт хүчин төгөлдөр болно...”

тасгийн эрхлэгчээр хянагдаагүй ба захиалгын хуудсанд эмийн нэрийг зөв бичээгүйгээс санхүүгийн программ дах нэрээс зөрүүтэй, эмийн дотоод шилжүүлгийн орлогыг тухай бүр бүртгэлд тусгадаггүй, тасаг нэгжээс ирүүлсэн захиалгын хуудсын дагуу эмийн зарцуулалтыг хөтлөөгүй байна.

Аудитад түүврийн аргыг ашиглан 16 тасгийн эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтыг тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Захиалгын хуудсаар тасгуудад олгосон эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн программд дутуу зарлагадсан байна. Энэ нь нөөцийн тасгаас эм олгох хэсэгт олгосон дотоод шилжүүлгийг санхүүгийн программд тухай бүр бүртгээгүйгээс дараа, дараагийн саруудад нөхөж зарлагадсантай холбоотой байна.

2. Эмчлэгч эмчийн бичсэн эм тариа эмийн санд байхгүй тохиолдолд үйлчилгээ ижил эм тариагаар орлуулж өгдөг, тариагаар олгохоор байхад уухаар буюу эмээр олгосон, өөр өөр савалгаатай нэг төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг хооронд нь гүйлгэж зарцуулсан, байхгүй эмийн оронд орлуулах эмийг олгож байгаа тохиолдолд тэмдэглэгээ хийдэггүй зэрэг алдаа зөрчил нийтлэг илэрлээ.

3. Нягтлан бодох бүртгэлд анхан шатны баримтгүй гүйлгээг бүртгэсэн, захиалгын хуудсаар олгосон эмээс илүү дүнгээр зарлагдаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁴, 13.7⁵ дах заалтыг зөрчсөн байна. Иймд баримтгүй зарлагадсан эмийн үнийн 143,6 мянган төгрөгийг холбогдох эд хариуцагч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Нэгдсэн эмнэлгийн эмийн сангаас үлдэгдлээр байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийг 7 хоног тутам тасаг, нэгжүүдэд мэдээлж байгаа гэх боловч нотлох баримт байхгүй, олгох хэсгийн эмийн санчийн эмийн зарлагын баримт, тасгуудын захиалгын хуудсанд гүйцэтгэсэн болон хянасан ажилтны гарын үсэг дутуу, түүнд эмийн нягтлан бодогч тухай бүрд хянаж шалгаж авдаггүй, эмийн зарцуулалтад байгууллагын ерөнхий нягтлан бодогч хяналт тавьдаггүй байна. Иймд цаашид эрх бүхий албан тушаалтнаар хянагдсан анхан шатны баримтыг үндэслэн эмийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлд тусгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.2.2 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Удирдах зөвлөлийн 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын 08 тоот шийдвэрээр “Өөрөөс хэрэглэсэн эмийн үнийн

⁴ "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ."

⁵ "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно."

эргэн олгох журам”-ыг баталсан байна. Тус журмаар зайлшгүй шаардлагаар өвчний түүхэнд нь бичигдсэн эм, тариаг өөрөөс нь гаргуулж хэрэглэсэн тохиолдолд эм, тарианы үнийг тухайн иргэнд буцаан олгохоор заасан байна. Ингэхдээ тухайн гаднаас авч хэрэглэсэн эм, тариа нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон бол эм, тарианы үнийг тендерийн худалдан авалтын үнээр, жагсаалтад ороогүй, сүүлийн үеийн эмчилгээ оношлогоонд хэрэглэж байгаа эм, тарианы үнийг тухайн эмийн тендерийн жишиг үнийн 50 хүртэлх хувиар тооцож олгохоор заажээ.

Эмийн нягтлан бодогчийн хийсэн дотооддоо боловсруулсан төсвийн хуваариар өөрөөс хэрэглэсэн эмийн үнэнд 2016 онд 3600,0 мянга, 2017 онд 5400,0 мянган төгрөг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 2016 онд 2720,9 мянга, 2017 онд 4461,1 мянган төгрөгийг иргэдэд буцаан олгосон байна.

Аудитад хамрагдсан онуудад иргэдэд олгосон эм, тарианы үнийн дүнг тасаг тус бүрээр судалж үзэхэд 2016 онд дотрын тасаг, 2017 онд хөнгөвчлөх тасагт хэвтэн эмчлүүлэгчид нийт зардлын дийлэнх хувийг олгосон байна.

№	Тасгийн нэр	2016 он		2017 он	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Дотор	7	1,235,060	6	648,654
2	Эрчимт	3	539,201	3	1,055,399
3	Хүүхэд	1	143,470	1	139,000
4	Мэс засал	1	55,880	1	481,543
5	Арьс	4	350,200	-	-
6	Мэдрэл	3	200140	-	-
7	Халдварт	1	88,000	3	926,500
8	Хөнгөвчлөх	2	108,900	14	1,138,800
9	Төрөх эмэгтэйчүүд	-	-	1	63,250
10	Гэмтэл	-	-	1	8,000
Дүн		22	2,720,851	30	4,461,146

Аудитаар анхан шатны баримтыг тулган шалгахад 2017 оны 10 дугаар сарын 12-ноос 23-ний хооронд дотрын тасагт хэвтэн эмчлүүлсэн иргэнд эмийн үнэнд 113,8 мянган төгрөгийг олгохдоо “Мөнхийн тун” ХХК-ийн 10 дугаар сарын 25-ний өдрийн баримт хавсаргасан зөрчил илэрсэн тул эмийн нягтлан бодогчоор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Өөрөөс хэрэглэсэн эмийн үнийг олгохдоо иргэдээс ирүүлсэн е-баримттай зарлагын баримтаас хувь хүний орлогын албан татвар суутган тооцож, Нэгдсэн эмнэлгийн кассаар олгодог байсанд санхүүгийн тайлангийн аудитаар татвар суутган

тооцохгүйгээр иргэдийн харилцах дансаар дамжуулах зөвлөмж өгснийг 2018 онд хэрэгжүүлэн ажилласан байна.

2.2.3 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 3 удаагийн тушаалаар 2016 онд 11653,4 мянга, 2017 онд 5868,8 мянган төгрөгийн эм акталсан бөгөөд акталсан эмийн 86,8% нь хүчинтэй хугацаа дууссан, 12,7% нь хагарч, гэмтсэн, 0,5% нь шошго уншигдахгүйн улмаас актлагдсан байна.

Он	Акталсан эмийн төрөл	Актлах эмийн дүн	ҮҮНЭЭС		
			Хүчинтэй хугацаа дууссан	Хугарч, хагарч гэмтсэн	Шошго уншигдахгүй болсон, ажиллагаагүй болсон
2016	71	11,653,408.55	10,846,162.80	708,045.74	99,200.00
2017	74	5,868,781.80	4,354,950.00	1,513,831.80	-

2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Баянхонгор эм хангамж” ХХК-аас худалдан авсан, нэг бүр нь 847,0 мянган төгрөгийн 3 ширхэг, нийт 2541,0 мянган төгрөгийн дутуу төрсөн нярайд хэрэглэгддэг Куросурф эмийг захиалга өгсөн төрөх эмэгтэйчүүдийн тасаг авч хэрэглээгүйн улмаас 10 дугаар сард хугацаа дуусч акталсан байна.

Дутуу нярайн амьсгал хямралын үед хийгддэг тус эмийг төрөх, эмэгтэйчүүдийн тасгаас 2017 онд хэрэглэхээр 10 ширхэгийг захиалсан ба 2017 оны эхний улиралд хэрэглэхээр хуваарилсан 3 ширхэгийг авсан боловч, “тус эмийг мэргэжсэн дадлага туршлагатай эмч тусгай аппаратаар хийдэг учир эмчилгээнд хэрэглээгүй” гэсэн тайлбарыг бидэнд нарийн мэргэжлийн эмч өгсөн болно.

Тусгай багаж төхөөрөмж, нарийн мэргэжлийн эмч бэлтгэж хэрэглэх нөхцөл бүрдээгүй байхад өртөг өндөртэй эмийг захиалж, дуусах хугацаа ойртсон эм авсан атлаа түүнийг солилцох арга хэмжээ авалгүй акталж, төсвийн хөрөнгөнд үрэлгэн хандсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын тушаал гараагүй байхад эмийг санхүүгийн программаас эмийг хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁶, 13.7⁷ дах, эм, биобэлдмэлийг устгахдаа байгууллагын өмч хамгаалах

⁶ “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.”

⁷ “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.”

байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслээгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3⁸ дах заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд цаашид эм, тарианы хугацаа дуусахаас 3 сарын өмнө байгууллагын дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, ерөнхий нягтлан бодогч нарт мэдэгдэж, зохих арга хэмжээг авч, ямар шалтгаанаар тухайн эм актлагдах болсон шалтгааныг тодруулж, гэм буруутай этгээдээр эмийн үнийг нөхөн төлүүлэх, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр эмийг акталж, холбогдох журамд заасан горимын дагуу эм, бэлдмэлийг устгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.2.4 Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2016 онд 11879 хэвтэн эмчлүүлэгчдийн эмийн зардалд 1088,1 сая, 2017 онд 11245 хэвтэн эмчлүүлэгчдийн эмийн зардалд 1243,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг зөв тайлагнасан бөгөөд нэг эмчлүүлэгчид ногдох эм, эмнэлгийн хэрэгслийн зардал дунджаар 2016 онд 66,0 мянга, 2017 онд 70,0 мянган төгрөг болж өссөн үзүүлэлттэй байна.

Сангийн яамнаас батлагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг эмийн нягтлан бодогч дотооддоо төсвийн хуваарь хийж, тасаг, нэгжүүдэд хуваарилахдаа 50,5-93,1 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна. Гэвч оны эцэст батлагдсан төсвийг 2016 онд 67,1 сая, 2017 онд 33,4 сая төгрөгөөр нэмж тодотгосон байхад тасаг, нэгжүүдэд зардлыг нэмж хуваарилаагүй байна.

Он тус бүрээр харьцуулбал:

Он	Анх батлагдсан төсөв	Эмийн нягтлан бодогчийн хийсэн тасгуудын эмийн төсвийн хуваарь	Зөрүү
2016 он	1093.8	1000.7	93.1
2017 он	1150.5	1100	50.5

Энэ талаар эмийн нягтлан бодогчоос тодруулахад “Яаралтай нөхцөл байдал үүссэн буюу тарваган тахал өвчин гарсан үед зарцуулах зорилгоор үлдсэн санхүүжилтийг хуваарилаагүй үлдээдэг” гэсэн тайлбар өгсөн болно.

Эмийн нягтлан бодогч оны эхэнд бэлтгэсэн дээрх төсвийн хуваарьт үндэслэн тасаг, нэгжүүдэд олгосон эмийн гүйцэтгэл, ор хоногийн ашиглалтыг харьцуулсан тайланг сар бүр бэлтгэж байгаа боловч санхүүгийн тайлан дах зардлын дүнгээс

⁸ “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх;”

2016 онд 1029,9 сая, 2017 онд 1161,7 сая төгрөгөөр эмийн зардлыг дутуу тайлагнаж тасаг нэгж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллаагүй байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр 24.6 дах заалтад заасны дагуу сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэг болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах эмгэг болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийг төлбөрийг төр хариуцаж иргэдэд үнэ төлбөргүй олгохоор зааж, 2012 онд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 129/100 тоот тушаалаар төлбөрийг нь төр хариуцах амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтыг баталж, жил бүр эмнэлгийнхээ төсөвт тусад нь дэд зүйл анги болгож тусган, уг эмээр тасралтгүй хангах асуудлыг шат шатны эмнэлгүүдэд хариуцуулсан байна.

Төлбөрийг төрөөс хариуцах эмийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийг харьцуулбал:

/мянган төгрөг/

Он	Төсвийн төсөлд тусгасан эмийн зардал	Төсвийн хуваариар батлагдсан эмийн дүн	Гүйцэтгэлээр олгосон эмийн дүн	Хэтрэлт - /хэмнэлт +
2016	16820.5	10800.0	6020.3	4779.7
2017	15374.8	11292.0	2070.2	9221.8

Төлбөрийг төрөөс хариуцах эмийн зардлыг аудитад хамрагдсан онуудад 4,7-9,2 сая төгрөгөөр хэмнэсэн атлаа эмчийн хяналтад байдаг иргэдийн 10 орчим хувьд нь үнэ төлбөргүй эм олгосон байна.

№	Өвчний нэр	Олгох эмийн тоо	2016 онд эмчийн хяналтанд байсан хүний тоо	2017 онд эмчийн хяналтанд байсан хүний тоо	Групп тогтоолгосон хүний тоо	2016 онд эм олгосон хүний тоо	Мөнгөн дүн	2017 онд эм олгосон хүний тоо	Мөнгөн дүн
1	Сүрьеэ	5	39	43	65	-	-	-	-
2	Хорт хавдарын 3,4-р үе /Хөнгөвчлөх эмчилгээ/	7	159	168	129	19	1,352,140.00	10	300,050.00
3	Сэтгэцийн эмгэг	9	205	213	663	5	213,600.00	10	120,560.00
4	Чихрийн шижин	8	87	114	43	69	3,482,498.40	48	1,220,100.00
5	Чихрийн бус шижин	1	2	3	13	3	630,000.00	3	375,000.00
6	Бамбай булчирхайн дутмагшил	2	87	92	47	3	14,154.27		
7	Өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил	1	5	5	12	-	-	-	-
8	Паркинсоны өвчин	1	21	24	12	-	-	-	-
9	Уналт таталт /Эпиледси/	2	250	260	247	5	327,880.00	3	54,500.00
10	Миастени	2	0	0	22	-	-	-	-
11	Нүдний даралт ихсэх өвчин /Глаукома/	2	110	120	28	-	-	-	-
12	Эрхтэн шилжүүлж суулгасны дараах	2	0	0	1	-	-	-	-
13	Дархлалын олдмол хомсдол өвчин	3	0	0		-	-	-	-
14	Гемофилий	1	0	0	1	-	-	-	-
	ДҮН	46	965	1042	1283	104	6020272.67	74	2,070,210.00

Иргэдэд олгосон эмийг өвчний төрлөөр нь авч үзвэл төлбөрийг төрөөс хариуцах эмийн зардлын дийлэнх хувийг чихрийн шижин өвчнөөр өвчилсөн иргэдэд олгожээ.

Аудитаар үнэ төлбөргүй эм авсан иргэдийн судалгааг гаргахад 2016-2017 онд хамгийн багадаа 2,500-3474, хамгийн ихдээ 341,340-180,000 төгрөгийн эм үнэгүй авсан бөгөөд үнэгүй эм авсан давтамж дараах байдалтай байна.

Эм авсан давтамж	2016 он		2017 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Үнэгүй эмийг 1-2 удаа авсан	86	3,629,250.27	68	1,427,010.00
Үнэгүй эмийг 3-5 удаа авсан	15	1,992,555.00	6	643,200.00
Үнэгүй эмийг 5-аас дээш удаа авсан	3	398,467.40	-	
Дүн	104	6,020,272.67	74	2,070,210.00

Сүрьеэгээр өвдсөн иргэнд Глобал сангийн санхүүжилтээр үнэгүй эм, тариа олгодог учир гүйцэтгэл гараагүй байна. Харин бусад 7 төрлийн өвчний төрөлд иргэдэд эм олгохгүй байгаа нь хариуцсан нарийн мэргэжлийн эмч иргэдэд эм бичиж өгдөггүйтэй холбоотой байна.

Аудитын явцад хийсэн судалгаануудаас үзэхэд аймгийн Нэгдсэн эмнэлэг төрөөс олгох эмийг хяналтад байдаг өвчтөнд олгодоггүй, мэдээлэл сурталчилгаа хийдэггүйгээс иргэд үүнийг мэдэхгүй өнгөрдөг байдал ажиглагдаж байна.

Иймд цаашид төрөөс олгох эмийг иргэдэд сурталчлах, иргэдэд жигд, хүртээмжтэй олгох зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлэв.

Төлбөрийг нь төрөөс хариуцах эмийг олгоход эмийн нягтлан бодогч хяналт тавьдаггүй, иргэдээр бүртгэсэн хөтлөлт байхгүй, стандартын бус жорыг мөрддөг, төлбөрийг нь төр хариуцах эмийн зарцуулалтын тайланг гаргаагүй нь 2012 оны Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 129/100 тоот тушаалаар батлагдсан “Төлбөрийг нь төр хариуцах журам”-ын 1.9⁹-т заасныг зөрчсөн байна.

Санхүүгийн программаас хөрвүүлсэн 2016 оны эмийн зардлын дүн эмийн сангийн гарган баталгаажуулж архивласан эмийн зарцуулалтын тайлангийн дүнгээс зөрүүтэй байснаас шалтгаалж, аудитад нэмэлт хугацаа шаардагдаж аудитын хугацаа хойшлогдсон болно. Зардлын дүн зөрсөн шалтгааныг тодруулж шалгахад 2016 оны эцэст санхүүгийн программ эвдэрсний улмаас зарим саруудын программд зарлагаар бүртгэсэн эм 12 дугаар сард үлдэгдлээр байсан тул программд зөрсөн үлдэгдлийг дахин оруулсан гэсэн тайлбарыг бидэнд ирүүлсэн. Үүнийг нотлохын тулд эд хариуцагч нарын баталгаажуулан бүртгэсэн эмийн

⁹ "Эмнэлгийн байгууллагууд төлбөрийг нь төр хариуцах эмийн зарцуулалтын тайланг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст улирал тутам гаргаж ирүүлнэ"

зарцуулалтын тайланг сар бүрээр гаргаж тулган шалгахад санхүүгийн программд бүртгэсэн дүн устаж нөхөн оруулсан болох нь нотлогдсон болно.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайлан бэлтгэж байгаа программын бодлого ба горимуудыг үнэлэхэд өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тул цаашид санхүүгийн программын аюулгүй, найдвартай байдлыг хангаж, эмийн иж бүрэн программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3

Санхүүгийн тайланд өглөг, авлагыг үнэн зөв тусгаж, хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Санхүүгийн тайланд өглөг, авлагыг үнэн зөв тусгаагүй, эмийн эмчилгээг зохицуулах хорооноос тавих хяналт зарим талаар хангалтгүй байна.

3.1 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлээгүй зөрчилд зөвлөмж өгсний үр дүнд 2017 онд бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж, хугацаанд нь актаар баталгаажуулсан байна.

3.1.1 Эмийн нягтлан бодогч Улаанбаатар хотын аж ахуйн нэгжүүдтэй цаг тухай бүрт нь утсаар болон цахим шуудангаар тооцоо нийлж байгаа бөгөөд хагас, бүтэн жилээр түүнийг шуудангаар ачаа тээвэрлэж буй машинаар илгээж тооцоог баталгаажуулдаг байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5 аж ахуйн нэгж байгууллагатай тулган баталгаажуулалт хийсэн бөгөөд 2016, 2017 оны бэлтгэн нийлүүлэгчдээс хамгийн их дүнтэй 5 аж ахуйн нэгжтэй тулган баталгаажуулалт хийхээр Улаанбаатар хотод нэг аудитор томилолтоор ажиллав.

Томилолтоор аймгийн Нэгдсэн эмнэлгийн худалдан авалтын журналыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын эмийн борлуулалттай тулган шалгасан бөгөөд “Монгол фарм” ХХК, “Сетунари” ХХК-ийн холбогдох хүмүүстэй уулзаж, “Мөнхийн тун” ХХК-ийн эмийн борлуулалт хариуцсан нягтлан бодогчтой утсаар холбогдож тулган баталгаажуулалтыг хийхэд зөрүү гараагүй болно.

“Айвико” ХХК-тай тооцоо нийлэхэд 2016 оны 12 дугаар сард нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн 5,3 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна. Тооцоо нийлсэн акт үйлдээгүй талаар тус компанийн санхүүгийн албаны даргаас тодруулахад “тооцоо нийлсэн актыг үйлдэж орон нутгийн харилцагчид руу явуулдаг боловч баталгаажуулсан хариуг буцааж ирүүлдэггүй” гэсэн тайлбарыг өгсөн.

Харин “Бүрэн хайрхан сервис” ХХК-ийн нягтлан бодогч амралтаа авсан байсан бөгөөд утас нь холбогдох боломжгүйн улмаас томилолтын хугацаанд тооцоо нийлж чадаагүй бөгөөд 2018.08.28-нд тус компаниас холбогдоход аудитад шаардлагатай баримт материалыг шаардахад “Манай байгууллага харилцагчидтай тухай оны эцэст тооцоо нийлдэг, файл архивладаггүй, үндсэн баримтаас түүх боломжгүй нэхэмжлэхийг 1 хувь үйлдэж өөртөө хувь авч үлддэггүй” гэсэн тайлбарыг өгөв. Иймд аудитын тулган баталгаажуулалт хийхээс татгалзсан “Бүрэн хайрхан сервис” ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэж, цаашид дахин гэрээ байгуулахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

3.1.2. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж 2017 онд тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу тоолж, үр дүнг хэлэлцсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар баталсан “Эм, эмнэлгийн хэрэгслийг захиалах, хуваарилах, хүлээн авах, хадгалах, түгээхэд баримтлах дотоод журам”-ын 3.4¹⁰-д заасны дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн тооллогыг жилд 2 удаа, хагас жил, бүтэн жилээр хийхэд илүүдэл, дутагдал гараагүй байна.

Тооллогын талаарх мэдээллийг нэгтгэж харуулбал:

Төрөл	2016 он		2017 он	
	хагас жил	жилийн эцэс	хагас жил	жилийн эцэс
Тооллогын комисс томилсон тушаалын огноо	2016.06.22	2016.12.08	2017.06.27	2017.12.28
тушаалын дугаар	A/16	A/23	A/116	A/251
Гишүүдийн тоо	5	4	5	5
Тооллогын тайлан		бичсэн	бичсэн	бичсэн
Удирдлагын зөвлөлд танилцуулах хугацаа	2016.07.05	хугацаа тавиагүй	2017.06.29	2018.01.08
Удирдлагын зөвлөлд танилцуулсан хугацаа	танилцуулаагүй	танилцуулаагүй	2017.09.29	2018.01.09

2016 онд тооллогын комисс нь тооллогын бүртгэлийг хийсэн ч тооллогын тайлан болон удирдлагын зөвлөлд танилцуулсан хурлын тэмдэглэлийг хөтлөөгүй байгаа нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар баталсан “ Эм, эмнэлгийн хэрэгслийг захиалах,

¹⁰ “Нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн дагуу орлого болон зарлагын баримтын дагуу компьютерийн санхүүгийн программд хөтлөн сар тутамд тайланг бэлтгэнэ. Эм эмнэлгийн хэрэгслийн тооллогыг жилд 2 удаа, хагас жил, бүтэн жилээр хийж, үр дүнг нь байгууллагын удирдлагаат танилцуулна”

хуваарилах, хүлээн авах, хадгалах, түгээхэд баримтлах дотоод журам”-ын 3.4¹¹-д заасан заалтыг зөрчиж байна.

2017 онд Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны 171/111 тоот тушаалын хавсралт болох бараа материалын тооцоо бодсон баримтаар тооллогын үлдэгдлийг баталгаажуулсан ч хагас жилийн тооллогын дүнг 3 сарын хугацаа хэтрүүлж удирдлагын зөвлөлд танилцуулсан байна.

Аудитын явцад Нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн нөөцийн хэсэг, эм олгох хэсэгт 2018 оны 08 сарын 28-ны өдөр эмийн үлдэгдэлд биет тооллого хийлээ. Тооллогыг ахлах аудитор Б.Должмаагаар ахлуулан аудитор Б.Азбаяр, П.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл нарын бүрэлдэхүүнтэй нөөцийн тасгийн эм зүйч О.Жаргалмаа, эм олгох хэсгийн эм зүйч М.Сэргэлэн, эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг нар тооллогыг хийв.

2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн санд 205,2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн 48,5% буюу 126 нэр төрлийн 99,6 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлд тооллого явуулав.

Нөөцийн тасгийг эм зүйч О.Жаргалмаа хариуцан ажиллаж байгаа ба тус өдөр эмийн нөөцийн тасагт 95163,9 мянган төгрөгийн 363 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл үлдэгдэлтэй байснаас түүврийн аргаар 56041,6 мянган төгрөгийн 93 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэлд биет тооллого хийхэд нийт 7026,0 мянган төгрөгийн зөрчил илрэв. Үүнд:

2018 оны 08 дугаар сард ЦССҮТ-д 400 ширхэг цусны хүүдийний төлбөрт 6400,0 мянган төгрөгийг шилжүүлж, бараа материалыг хүлээн аваагүй атлаа нөөцийн тасагт орлогоор бүртгэсэн, 336,6 мянган төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг сукасаметонин уусмал тооллогоор илүүдсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4¹² дэх заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Глизид М нэршлийн эмээс 13,7 мянган төгрөгийн 50 ширхэг илүүдсэн, Глимипирид эмээс 13,7 мянган төгрөгийн 50 ширхэг дутагдсан, 8,0 мянган төгрөгийн

¹¹ "Нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжийн дагуу орлого болон зарлагын баримтын дагуу компьютерийн санхүүгийн программд хөтлөн сар тутамд тайланг бэлтгэнэ. Эм эмнэлгийн хэрэгслийн тооллогыг жилд 2 удаа, хагас жил, бүтэн жилээр хийж, үр дүнг нь байгууллагын удирдлагаат танилцуулна"

¹² "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.."

үнэ бүхий 80 ширхэг карсил, 68,0 мянган төгрөгийн 7,5-300 мл-тэй 20 ширхэг темадин нөөцийн тасагт дутагдсан байхад олгох хэсэгт энэ зөрүүгээр илүүдсэн зэргээс харахад нөөц, олгох тасгийн эд хариуцагч нарын ажлын хариуцлага сул, тооцоог тухай бүр хөтөлдөггүйтэй холбоотой байна.

Аудитаар хийсэн биет тооллогоор нэг бүр нь 1,3 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг маск 99, нэг бүр нь 5,5 мянган төгрөгийн үнэ бүхий 20 ширхэг лаферобион лаа, нэг бүр нь 25,0 мянган төгрөгийн 2 ширхэг төвийн венийн катеатр зэрэг нь нөөцийн үлдэгдлээс илүүдсэн тул 160,0 мянган төгрөгийн дээрх эмийг орлогод авах албан шаардлагыг өгөв.

Эм олгох хэсгийг эм зүйч М.Сэргэлэн хариуцан ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдөр түүврийн аргаар 33 нэр төрлийн 111185 ширхэг эм, эмнэлгийн хэрэгсэлд биет тооллого хийхэд нийт 1411,1 мянган төгрөгийн зөрчил илрэв. Үүнээс 9 нэр төрлийн 1267 ширхэг буюу 468,2 мянган төгрөгийн дутагдал гарч холбогдох ажилчдаар гарын үсэг зурж баталгаажууллаа.

Дээрх дутагдсан эм, эмнэлгийн хэрэгслээс Hbsapg test, Hcv тестийг 2018 оны 08 дугаар сарын 24-ны өдөр анх хүлээн авсан ба эм найруулагч М.Сэргэлэн тестийг олгосон өрхийн эмнэлгүүд болон сумдын Эрүүл мэндийн төвүүдээс тодруулан дахин тооцоо нийлэхэд Хүрээмарал сумын ЭМТ-д Hbsapg test 240 ширхэг, Hcv тест 240 ширхэгийг илүү, Баацагаан сумын ЭМТ-д Hbsapg test 10 ширхэгийг дутуу олгосон байна гэсэн тайлбарыг Хүрээмарал сумын ЭМТ-өөс албан бичгээр ирүүлсэн болно. Иймд дээрх дутагдсан 125.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн үнийг олгох хэсгийн эм зүйч М.Сэргэлэнгээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Тооллогоор вакуум теннер буюу хуруу шил, уян зүү, церуглан зэрэг 9 нэр төрлийн 1677 ширхэг буюу 942,8 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл илүү тоологдсон зөрчил илэрсэн тул илүүдсэн эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авах албан шаардлагыг өглөө.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар батлагдсан амин чухал эмийн жагсаалтад бүртгэгдсэн 50 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийг тоолоход 8 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл үлдэгдлээр байхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлага, өглөгийг тухай бүр үнэн зөв хөтлөөгүй эмийн нягтлан Д.Ганхүлэгт Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

Нэгдсэн эмнэлгийн Эмийн сангийн олгох хэсэг эмийн нэр төрөл, үнэ зэргээр төрөлжүүлэлт болон хаягжуулалт байхгүй тооллого хийхэд эм, эмнэлгийн хэрэгсэл эмх цэгцгүй байрлуулсан байдалтай байна.

3.2. Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай хийсэн гэрээний хэрэгжилтэд эмийн эмчилгээг зохицуулах хороо хяналт тавьж ажиллаагүй байна.

3.2.1. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах” журмын 2.1.2¹³-т заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 60 дугаар тушаалаар “Эмэн эмчилгээний хороо байгуулах” шийдвэрийг гаргаж, хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хорооны ажиллах журмыг баталсан байна. Тус хорооны даргаар Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч С.Энхбаяр, нарийн бичгийн даргаар эм зүйч Б.Буяннэмэх нар томилогдон ажиллажээ.

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны 05 дугаар сарын 26-ны А/99 тоот тушаалаар өөрчлөн зохион байгуулж, хорооны даргаар эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Ч.Жавзанг томилж 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хорооны ажиллах журмыг шинэчлэн баталжээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмийн эмчилгээг зохицуулах хороо 2016 онд нийт 18, 2017 онд 12-н заалт бүхий хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, 2016 оны төлөвлөгөөг тус хорооны дарга буюу эмчилгээ эрхэлсэн орлогч дарга хянаж баталсан байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалаар батлагдсан Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах журмын 2.5¹⁴ дах заалтыг зөрчсөн байна.

Хорооны үйл ажиллагааны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар эмийн нягтлан бодогчоос тодруулахад Эмийн эмчилгээг зохицуулах хорооны төлөвлөгөөг боловсруулахдаа ямар нэг төсвийн төлөвлөлт хийдэггүй ба хорооны үйл ажиллагаатай холбоотой бичиг хэргийн зардлыг байгууллага шийдвэрлэж өгдөг гэсэн тайлбараас харахад “Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах журам”-ын 2.6¹⁵ дах заалт хэрэгжихгүй байна гэж үзэхээр байна.

¹³ “...аймгийн Нэгдсэн эмнэлэг нь эмчилгээ эрхэлсэн дарга, клиникийн эм судлаач, эм зүйчид, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал хариуцсан ажилтан зэрэг /7-оос доошгүй/ гишүүдээс бүрдэнэ”

¹⁴ “Хороо нь эмнэлгийн даргаар батлуулсан ажлын нарийвчилсан төсөв, төлөвлөгөөтэй ажиллана”

¹⁵ “Хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг эмнэлгийн байгууллага жил бүр төсөвтөө тусган, санхүүжүүлнэ.”

3.2.2 Эмийн эмчилгээг зохицуулах хороо эмийн солилцоо, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, журмаар баталсан үүргээ биелүүлээгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалаар батлагдсан Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах журмын 4.1.1¹⁶-т заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмийн эмчилгээг зохицуулах хорооны 2016 оны тайланг 2017 оны 01 сарын 04-нд, 2017 оны хорооны тайланг 2018 оны 01 дүгээр сарын 05-нд тус тус Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр хүргүүлжээ.

Эмийн эмчилгээний хорооны жилийн эцсийн тайланд тухайн жилд төлөвлөсөн ажлын биелэлтийг тооцож дүгнэсэн талаар Эмийн эмчилгээг зохицуулах хорооны 2016, 2017 оны үйл ажиллагааны тайлан мэдээг үнэлж, дүгнэсэн талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг ирүүлээгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, зарцуулалтыг шалгахад эмийн солилцоог эмийн нягтлан бодогч, нөөцийн тасгийн эм зүйч нарын сонголтоор хийж ирсэн, хугацаа дууссан эмийг тусгаарлаж хадгалаагүй, тендерийн гэрээнд тусгагдаагүй болон гэрээний үнээс илүү үнээр эмийг худалдаж авсан, гэрээ байгуулаагүй аж ахуй нэгжүүдээс худалдан авалт хийсэн зэрэг алдаа, зөрчлүүд илэрсэн нь Эмийн эмчилгээг зохицуулах хорооноос тавих хяналт сул байгаатай холбоотой байна.


Эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж ажиллахгүй байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалаар батлагдсан Эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллах журмын 4.1.1¹⁷ дэх хэсгийг хэрэгжүүлээгүй байгаа тул цаашид эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр тасаг, нэгжээр гаргаж байх зөвлөмжийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргад хүргүүлэв.

Аудитаар нийт 741,4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс 1,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 732,3 төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

¹⁶ “... эмнэлгийн эмийн хэрэглээний талаархи мэдээ тайланг бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдэгээр баталгаажуулан Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст дараа оны 01 сарын 10-ны дотор бичгээр болон цахим хаягаар хүргүүлнэ”

¹⁷ “... эмнэлгийн эмийн хэрэглээний талаархи мэдээг сар бүр дотооддоо гаргаж...”

Холбогдох байгууллагын санал


ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
Ц.МАГСАРЫН НЭРЭМЖИТ
НЭГДСЭН ЭМНЭЛЭГ**
64103 Дуурсах, Баянхонгор сум
Утас 70-44-29-43
E-mail ne_bhr@yahoo.com

2018.09.10 431


Танай _____ -ны № _____ Т

Г Санал хүргүүлэх тухай Г

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016, 2017 оны эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах болно.

2016, 2017 онд гэрээт эм ханган нийлүүлэх байгууллагууд тендерийн захиалсан тоо хэмжээнд нийлүүлэхээр санал болгосон үнийн дагуу нийлүүлсэн. Валютын ханш өссөнтэй холбоотойгоор гадаадаас импортлож байгаа эмийн үнэ өсч байсан бөгөөд манай байгууллагын захиалсан нэмэлт тоо хэмжээгээр нийлүүлж эмчилгээ үйлчилгээнд доголдол гаргаагүй ажилласан. Үүнийг харгалзан үзнэ үү.

Эмч нарт эмийн жор бичилтийн стандартаар 3 дугаар сард тестээр сорил авч бичсэн жоронд судалгаа хийн илэрсэн зөрчлүүдэд дүгнэлт гаргасны үндсэн дээр сургалт явуулж, гарын авлага бэлдэн тарааж өгсөн бөгөөд жор бичилт нь эмийн хадгалалтын горимд хамааралгүй болно. Энэ нь эмийн эмчилгээг зохицуулах хорооноос авч явуулсан ажлын нэг юм.

ЭМЧИЛГЭЭ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ
ДАРГА  Ч.ЖАВЗАН

D:/2018 on/2018 on tom toot
5418010

Саналд өгөх тайлбар:

Тендерийн захиалсан тоо хэмжээнээс илүү хэмжээгээр нийлүүлэлт хийгдсэн талаарх саналыг харгалзаж, гэрээнд заасан тоо хэмжээнээс илүү тоо хэмжээг өндөр үнээр бэлтгэсэн зөрчилд тогтоосон төлбөрийн актыг байгууллагын онцлогоос шалтгаалж эргэн тооцож, төлбөрийн актыг бууруулсан.

Эмийн эмчилгээний хороотой холбоотой ирүүлсэн саналыг хүлээн авч тайланд тусгав.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг Сангийн яамнаас бууруулж баталснаас эмийн өглөг үүсч, оны эцэст зардлыг нэмж тодотгосон байна.
2. Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2016 онд 372.7 сая, 2017 онд 315.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлд тендерийн бус худалдан авалт хийсэн байна.
3. Гэрээ байгуулаагүй аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн, тендерийн гэрээний үнээс өндөр үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэсэн байна.
4. Сар бүр тасаг, нэгжүүдэд тайлагнасан эмийн зарцуулалтын тайланг үнэн зөв гаргаагүй байна.
5. Санхүүгийн программийн удаа дараагийн гэмтэл нь эмийн бүртгэлийн хэвийн ажиллагааг алдагдуулж байна.
6. Эмийн дотоод шилжүүлгийг тухай бүр бүртгэлд тусгадаггүйгээс тасаг нэгжээс ирүүлсэн захиалгыг зөрүүтэй дүнгээр бүртгэж, зөрүүг дараагийн саруудад нөхөн бүртгэж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн байна.
7. Эмийн солилцооны журам байхгүй, санхүүгийн программд эмийн хүчинтэй хугацааг оруулдаггүй, солилцоогоор авсан зарим эмийг тендерийн үнээс өндөр үнээр авсан байна.
8. Эмнэлгийн даргын тушаалаар томилогдсон эм хүлээн авах комисс эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч акт үйлдээгүй байна.
9. Өөрөөс хэрэглэсэн эмийн үнийн эргэн олгох журмыг зөрчиж шаардлага хангахгүй баримтад үндэслэн иргэнд зардлыг нөхөн олгосон байна.
10. Иргэдэд төлбөрийг төрөөс хариуцах эмийн зардлыг төлөвлөсөн хэмжээнд олгоогүй байна.
11. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл болон Нэгдсэн эмнэлгийн даргын шийдвэр гараагүй байхад эмийг акталж устгасан байна.
12. Эмийн эмчилгээг зохицуулах хорооноос тавих хяналт зарим талаар хангалтгүй байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох танаа:

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийн багцын захиалгыг батлагдсан төсвөөр өгч байх.
2. Тухайн жилийн өвчлөл болон гэнэтийн шаардлагаас хамаарч худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээ өөрчлөгдөх зэрэг салбарын онцлогийг техникийн тодорхойлолт болон гэрээний тусгай нөхцөлд тусган, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх.
3. Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай байгуулсан гэрээний дүнд багтаан тендерийн үнээр дуусах хугацаа урттай эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын тушаалаар томилогдсон комисс актаар эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч байх.
4. Эм ханган нийлүүлэгч байгууллагуудаас авсан эм, эмнэлгийн хэрэгслийг санхүүгийн программд тухай бүр оруулж, санхүүгийн тайланд авлага, өглөгийг үнэн зөв тусгаж, тасгуудаас ирүүлсэн захиалгын хуудсын дагуу бүртгэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах.
5. Эмийн төсвийг зарцуулахдаа дотоод тасаг, нэгжид зардлыг зөв хуваарилж, санхүүгийн тайланд тулгуурлаж эмийн зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх.
6. Эмийн эмчилгээг зохицуулах хороо эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр тасаг, нэгжээр гаргаж, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт, эмийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.
7. Эм, эмнэлгийн хэрэгсэл актлагдах болсон шалтгааныг тодруулж, гэм буруутай этгээдээр эмийн үнийг нөхөн төлүүлж, байгууллагын дарга, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбогдох журамд заасны дагуу эм, бэлдмэлийг устгаж байх.
8. Төлбөрийг төрөөс хариуцах эмийн жагсаалт, өөрөөс хэрэглэсэн эмийн үнийн эргэн олголтын талаар иргэдэд мэдээллийн самбараар сурталчилж, тухайн зардлуудад батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, иргэдэд тэгш хүртээмжтэй олгох.
9. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргаар батлуулсан эм, эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой одоо мөрдөгдөж байгаа журмуудыг холбогдох хууль, журамд

- нийцүүлэн шинэчилж, эм тариа акталж устгах, эм солилцох журмыг шинээр боловсруулан баталж, амин чухал хэрэгцээтэй эм тарианы нөөцийг тогтоож, ЭМС-ын 2009 оны 388 тоот тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
10. Эмийн хэмжих нэгж, нэршил, кодчилол, хүчинтэй хугацаа зэргийг тусгасан, хэрэглэгчийн хандах эрхийг хязгаарласан эмийн иж бүрэн программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.
 11. Гүйцэтгэлийн аудитаар тулган баталгаажуулалт хийхээс татгалзсан аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээг дүгнэж, цаашид дахин гэрээ байгуулахгүй байх.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний дүнг худалдан авалттай харьцуулсан судалгаа

№	Компаний нэр	2016 он			2017 он		
		Нийт гэрээний нийлбэр дүн	Хүлээн авч бэлтгэлд тулгарсан зэмнэг дүн	Зөрүү	Нийт гэрээний нийлбэр дүн	Хүлээн авч бэлтгэлд тулгарсан зэмнэг дүн	Зөрүү
1	Монгол фарм ХХК	144,387,100	141,724,270	2,662,830	12,127,900	124,032,890	(123,030,420)
2	Сүхэн уул ХХК	12,187,800	8,218,884	3,970,916	62,681,380	63,333,648	6,327,732
3	Бүрэн хайрлал сөрөг ХХК	62,002,300	69,020,169	(7,017,869)	117,708,285	117,238,731	(4,302,015)
4	Евро фарм ХХК	3,200,000	4,733,057	(1,533,057)	2,394,000	1,057,440	1,336,560
5	Нилдбулаг галч ХХК	23,200,000	32,323,503	(9,123,503)	7,100,000	2,791,300	(1,087,527)
6	Эн хэвдээс ХХК	45,293,485	30,131,984	15,161,501	171,789,257	100,111,080	71,678,277
7	Монгол фарм трейд	123,661,020	173,225,438	(49,564,418)	66,613,000	117,205,808	(28,592,808)
8	Энх ойд эйн ХХК	2,620,000	1,310,000	1,310,000	2,290,000	1,530,000	720,000
9	Монгол ХХК	3,200,000	7,721,000	(4,521,000)	8,590,000	8,945,000	(15,000)
10	Модстайн ХХК	-	1,170,000	(1,170,000)	-	-	-
11	Милорад	1,080,000	4,370,000	(3,290,000)	2,900,000	2,700,000	200,000
12	"Налин" ХХК	24,388,900	38,652,090	(14,263,190)	19,140,750	28,993,380	(7,442,630)
13	"Али фарм" ХХК	16,428,194	16,175,475	252,719	3,897,832	1,768,600	2,047,602
14	"Цэмбэ"	13,477,250	14,140,600	(663,350)	-	-	-
15	"Монфа" ХХК	5,508,000	8,893,780	(3,385,780)	11,590,440	10,368,020	1,184,420
16	"Айвак" ХХК	104,043,300	212,872,070	(108,828,770)	177,825,456	160,183,404	(2,357,548)
17	"Ойбол" ХХК	4,472,600	3,628,700	843,900	-	-	-
18	"Маскоин тус" ХХК	79,789,150	123,937,890	(44,148,740)	129,662,100	143,978,484	(14,316,384)
19	"Нарт Эрдэнэ" ХХК	195,990,000	49,519,100	146,470,900	-	-	-
20	"Дэв" ХХК	15,808,600	39,709,800	(23,901,200)	14,662,000	25,971,880	(11,309,880)
21	"Баянгол Мед" ХХК	13,662,000	39,318,960	(25,656,960)	16,289,800	27,754,060	(11,464,460)
22	"Ситүмари" ХХК	158,702,904	113,014,332	45,688,572	178,702,544	178,682,453	20,091
23	Саммит сөрөг ХХК	12,370,000	12,825,000	(455,000)	11,880,000	10,415,000	1,245,000
24	ЦС СҮТ	2,000,000	4,050,000	(2,050,000)	6,960,000	8,380,000	(1,420,000)
25	Богд хун олонгол	-	200,000	(200,000)	-	-	-
26	Етөл ХХК	-	2,454,000	(2,454,000)	660,000	660,000	-
27	Итгэрсэлэг ХХК	-	748,000	(748,000)	-	-	-
28	Лавра центр	-	2,340,000	(2,340,000)	-	-	-
29	Марна столиц	-	3,030,000	(3,030,000)	4,080,000	3,835,000	455,000
30	Нуган трейд	-	7,668,600	(7,668,600)	14,549,900	20,701,300	(6,151,400)
31	Талын ус	-	80,000	(80,000)	-	-	-
32	Хантоль	-	285,000	(285,000)	-	-	-
33	ШУТТЭнэтлэг	-	160,000	(160,000)	-	320,000	(320,000)
34	Шуран хан уул	-	1,700,000	(1,700,000)	-	-	-
35	ЭМГ ЗОС	-	5,476,880	(5,476,880)	-	-	-
36	Арван ХХК	-	-	-	-	1,275,796	(1,275,796)
37	Монголрэнгэ	-	-	-	450,000	600,000	(150,000)
38	Энхтэй	-	-	-	-	-	-
	ДҮН	1,098,463,883	1,172,483,940	(73,995,957)	1,085,730,014	1,189,883,824	(123,671,190)

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн солилцсонд хийсэн судалгаа

Хавсралт №2

/ мянган төгрөг/

2016 он								
дд	Бэлтгэн нийлүүлэгчид	Нэгдсэн эмнэлгийн эмийн сангаас солиулахаар зарлагдсан эмийн			Бэлтгэн нийлүүлэгч компаниас солигдож ирсэн эмийн			Зөрүү
		нэр төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн	нэр төрөл	Тоо ширхэг	Солилцсон үнийн дүн	
1	ЭМГ ЭЭС	8	4100	398.9	5	141	398.9	0
2	Богд хүн эмнэлэг	1	10	200	3	1100	200	0
3	"Наянбулаг ганга" ХХК	87	7425	2960.4	64	167183	2960.4	0
4	"Монс фарм трейд" ХХК	3	534	565.6	5	4200	565.6	0
5	"Мөнхий тун" ХХК	30	198672	14713.9	28	47457	14803.9	-90.0
	Нийт	129	208741	18838.8	103	220051	18928.8	-90.0
2017 он								
дд	Бэлтгэн нийлүүлэгчид	Нэгдсэн эмнэлгийн эмийн сангаас солиулахаар зарлагдсан эмийн			Бэлтгэн нийлүүлэгч компаниас солигдож ирсэн эмийн			Зөрүү
		нэр төрөл	Тоо ширхэг	Солилцсон үнийн дүн	нэр төрөл	Тоо ширхэг	Солилцсон үнийн дүн	
1	"Наянбулаг ганга" ХХК	99	7619	5376.2	23	2588	5376.2	0
2	"Энх тун" ХХК	5	322	59.4	1	33	59.4	0
3	"Монгол фарм" ХХК	25	48699	11185.2	28	41741	11185.2	0
4	"Бүрэн хайрхан" ХХК	13	11385	4851.6	18	16458	4851.6	0
		142	69025	21472.4	70	60800	21472.4	

.....000.....

Эмийн солилцоогоор авсан эмийг гэрээний үнэтэй харьцуулсан судалгаа

ДД	Нэр	Солилцооны үнэ	гэрээний үнэ	Зөрүү	Хувь	Х.Н	Тоо	Хэмнэлт
1	Рингер 500	3,250.00	1,987.00	1,263.00	63.56	фл	300	378,900.00
2	Цераксон 500 мг/4 мл	8,840.00	5,826.00	3,014.00	51.73	ам	25	75,350.00
3	Шприц 0,5	150	100	50	50	ш	3,600	180,000.00
4	Шприц 10	190	125	65	52	ш	2,400	156,000.00
5	Граммын будаг	70,000.00	45,000.00	25,000.00	55.56	ш	5	125,000.00
6	Аскорутин	35	22.5	12.5	55.56	ш	4,000	50,000.00
7	Валокордины дусаалга	8,000.00	5,200.00	2,800.00	53.85	ш	10	28,000.00
8	Калтоприл	65	30	35	116.67	ш	80	2,800.00
9	Пирацетам	280	144	136	94.44	ш	780	106,080.00
10	Флуконазол 100 мл	3,800.00	1,380.00	2,420.00	175.36	фл	200	484,000.00
11	Церуглан	1,100.00	560	540	95.43	ам	300	162,000.00
12	Кавинтон	700	240	460	191.67	ш	30	13,800.00
13	Суксаметонин	2,500.00	1,320.00	1,180.00	89.39	ам	10	11,800.00
	Дун						11740	1,773,730.00

.....000.....